



## “ХӨШӨӨТ” ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ХОВД АЙМГИЙН БАРИМТЛАХ БОДЛОГО

### **Нэг. Зорилго**

“Хөшөөт” төслийг хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж, уул уурхайн үйл ажиллагааг хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүй эрхлэх, нөхөн сэргээх, төслийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг Ховд аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлоготой уялдуулан ил тод, үр ашигтай хамтын ажиллагааг хэрэгжүүлэхэд оршино.

### **Хоёр. “Хөшөөт” төслийг хэрэгжүүлэхэд баримтлах бодлого**

2.1. “Хөшөөт” төслийг хариуцлагатай уул уурхайн нийгмийн өмнө хүлээх хариуцлагын зарчимд нийцсэн, хүн ам, байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүй байх нөхцөлтэйгөөр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах.

#### **А. Төсөл хэрэгжүүлэгч МоЭнКо ХХКомпаний хувьд:**

2.1.1. Гэрээт талбай болон уурхайн эдэлбэрээс ашигт малтмал хайх, нүүрс олборлох, түүний ашигт агуулгыг нэмэгдүүлэх, баяжуулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, тээвэрлэх, борлуулах болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагааг Ашигт малтмалын тухай Монгол улсын хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэх;

2.1.2. Ашигт малтмалын нөөцийг бүрэн ашиглах ба зөвхөн ашиг олох зорилгоор сорчлон олборлохгүй байх;

2.1.3. Үйлдвэрлэлийн шаардлагатай дэд бүтэц, барилга байгууламж барих;

2.1.4. Үндсэн үйл ажиллагааг хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд аль болох сөрөг нөлөө багатайгаар явуулах;

2.1.5. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлсон төлөвлөгөөний дагуу үйлдвэр, уурхайн орчин, замын маршрутын дагуу хөрс, ургамал, булаг шанд, гол горхи, ан амьтан хамгаалах ажлыг зохион байгуулж, холбогдох нөхөн сэргээлт хийх;

2.1.6. МоЭнКо компани нь Хөшөөт багийн шинэ төвийг барих ажлыг Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу 2014 оны 5 дугаар сараас эхлэн шинэ суурьшлын бүсийн гэрэл цахилгаан, цэвэр усаар хангах зэрэг иргэдийн амьдралд нэн түрүүнд шаардлагатай дэд бүтцийг бий болгож, айл өрхийн хашааг барьж байгуулсны дараа иргэдийн нүүлгэн шилжүүлэлт хийх;

2.1.7. МоЭнКо компани хөшөөт багийн төвийг нүүлгэн шилжүүлж дуусах хүртэл хугацаанд багийн иргэдийг ундны болон ахуйн хэрэгцээний усаар хангаж одоо олгож буй сүүний нөхөн олговрыг тасралтгүй олгох үүрэг хүлээх;

2.1.8. МоЭнКо компани нь орон нутгийн хөгжил, иргэдийн боловсрол, эрүүл мэнд, соёл, спорт, аялал жуучлал болон уламжлалт мал аж ахуй, газар тариалангийн салбарыг дэмжих чиглэл болон хот төлөвлөлт, тохижилтийн ажилд мөнгөн болон бусад хэлбэрээр хөрөнгө оруулалт хийж, хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавих байдлаар нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлж ажиллах;

2.1.9. МоЭнКо компани авто замыг даатгалын байгууллагад бүрэн даатгуулж, замын засвар, үйлчилгээг өөрийн санхүүжилтээр орон нутгийн аж ахуйн нэгж, иргэдээр гүйцэтгүүлэх;

2.1.10. “Хөшөөт” төслийг хэрэгжүүлэх явцад хөшөөтийн уурхайг түшиглэн нүүрсийг коксжуулах үйлдвэр болон 36 мвт-ын цахилгаан станц барих асуудлыг үргэлжлүүлэн судалгаа хийж шийдвэрлэх;

## **Б. Ховд аймгийн хувьд:**

2.1.10. Нүүрсний нөөц нэмэгдүүлэх, ундны болон үйлдвэрлэлийн усны нарийвчилсан хайгуул, уурхай, үйлдвэр, суурин байгуулах байгаль орчны үнэлгээ хийх асуудлыг дэмжиж, холбогдох хуулийн хүрээнд хяналт тавих;

2.1.11. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг батлагдсан үнэлгээний дагуу хийгдэж буй эсэхэд хяналт тавьж, хамтран ажиллах;

2.1.12. Үйлдвэр, уурхай, суурин түүний цахилгаан, дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ байгуулах, зам гүүр, барилга байгууламжийн газар олголт, бусад шаардлагатай зөвшөөрлийг олгох, шийдвэрлэж дэмжиж ажиллах;

2.1.13. МоЭнКо компани нь төслийн үр өгөөжийг нэмэгдүүлж, нүүрсний чанарыг сайжруулах, тээвэрлэлтийн зардлыг хэмнэх үүднээс нүүрсийг хуурай аргаар баяжуулах үйлдвэрийг ашиглалтанд оруулахад дэмжлэг туслалцаа үзүүлэх;

**2.2. “Хөшөөт” төслийг аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн тогтвортой өсөлтийг дэмжих бодлого болгон хэрэгжүүлэхэд талууд дараах бодлогыг хэрэгжүүлнэ.**

2.2.1. Улсын болон орон нутгийн татвар, төлбөр, хураамжийг тухайн төсөвт хуулийн хугацаанд оруулах;

2.2.2. Төслийн хүрээнд хийгдэх бараа, бүтээгдэхүүний хангалт, үйлдвэрлэл, ажил үйлчилгээг орон нутгийн иргэд, татварын албанд бүртгүүлсэн салбар нэгжүүдээр гүйцэтгүүлэх;

2.2.3. Ховд аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжихээр “Хөшөөт хөгжлийн сан”-г хамтран байгуулж ажиллах ба тус сангийн ажиллах журмыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар батлуулан мөрдөх;

2.2.4. “Ховд Хөшөөт хөгжлийн сан”-гийн хөрөнгийн эх үүсвэрийг жил бүр МоЭн Ко компаний экспортлож, борлуулсан нүүрсний хэмжээнээс үл хамааран 1,0 тэрбум төгрөг, экспортод гаргасан нүүрсний 1 тн тутмаас 1 ам. долларыг тооцож тус тус бүрдүүлж байх;

2.2.5. Санд 2014 онд төвлөрүүлэх хөрөнгийн хувьд МоЭнКо компаний үйлдвэрлэл, санхүүг дэмжих зорилгоор жил бүр төвлөрүүлэх 1.0 тэрбум төгрөгийг 600,0 сая төгрөгөөр, экспортод гаргасан 1 тн нүүрснээс авах 1 ам долларыг 0,6 ам доллар /60 цент/-аар тус тус тооцож бүрдүүлэх;

**2.3.Тухайн төслийг хэрэгжүүлэх явцад шаардлагатай бараа, ажил үйлчилгээг орон нутгийн аж ахуйн нэгж, иргэдээр гүйцэтгүүлэх талаар хамтран ажиллах.**

2.3.1. МоЭнКо Компани орон нутгийн аж ахуйн нэгжүүдийн чадавхийг дээшлүүлэх замаар төслийг хэрэгжүүлэхэд үйлдвэрлэл, үйлчилгээнд шаардлагатай бараа, ажил үйлчилгээний 50,0 –иас доошгүй хувийг орон нутгаас хангах;

2.3.2. Төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай бараа, ажил үйлчилгээний 50,0-иас доошгүй хувийг орон нутгийн аж ахуйн нэгжүүдээр гүйцэтгүүлэх замаар орон нутгийн жижиг дунд бизнесийг дэмжин чадавхижуулах, төслийн бараа, ажил үйлчилгээний ханган нийлүүлэх үйл ажиллагаанд тухайн бизнес үйлчилгээний шаардлага хангасан орон нутгийн аж ахуйн нэгжүүд давуу эрхтэйгээр оролцуулах;

2.3.3. Тээврийн хэрэгслэлүүд нь тээвэрлэлтийн нөхцөлд тохирсон, техникийн чанарын баталгаатай бөгөөд орон нутгийн тээвэрчдийн төлөөллийг оролцуулсан, Ховд аймгийн албан ёсны бүртгэлтэй аж ахуйн нэгж, тээврийн байгууллагаар тээвэрлэлтийн ажлын 50,0 -иас доошгүй хувийг гүйцэтгүүлэх;

**2.4. Төслийн хэрэгжүүлэхэд шаардлагатай боловсон хүчнийг орон нутгаас хангах.**

2.4.1. Орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах, үндэсний боловсон хүчнийг бэлтгэх, сургах;

2.4.2. Орон нутгийн иргэдээс сургууль, дамжаанд суралцуулах, улмаар ажлын байраар хангах асуудлыг хамтран зохион байгуулах;

2.4.3. Төслийн хүрээнд ажиллах нийт Монгол ажилчдын 70,0-аас доошгүй хувийг Ховд аймгийн иргэдээс бүрдүүлэх;

**2.5. Төслийг хэрэгжүүлэх явцад аймгийн ирээдүйн нүүрсний хэрэгцээг баталгаажуулан орон нутгийн шаардлагатай нүүрсний хэрэгцээг тасралтгүй хангах бодлогыг хэрэгжүүлэх;**

2.5.1. Орон нутгийн иргэд, байгууллагын дотоодын нүүрсний хэрэгцээг хангах ажлыг жил бүр Ховд аймагтай хамтран зохион байгуулах ба нүүрс ханган нийлүүлэлтийг саадгүй нийлүүлэх;

2.5.2. Орон нутгийн иргэд, байгууллагад дотоодын хэрэгцээний нүүрс нийлүүлэх үйл ажиллагааг орон нутгийн өмчийн хамтарсан хуулийн этгээд байгуулах замаар жил бүрийн 08 дугаар сарын 01-ний өдрөөс дараа жилийн 03 дугаар сарын 30-ны өдрийн хооронд саадгүй гүйцэтгэх;

2.5.3. МоЭнКо компани Ховд аймгийн ирээдүйн нүүрсний хэрэгцээг хангахаар 10,0 саяас доошгүй тонн нүүрсний нөөц бүхий талбайг гэрээний хугацаанд Ховд аймагт шилжүүлэх;

## **2.6. Төслийн хүрээнд нөлөөлөлд орсон байгаль орчинг нөхөн сэргээх ажиллагааг зохих журмын дагуу хийх.**

2.6.1. МоЭнКо компани хөрсний бохирдлыг зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, үйл ажиллагааны нөлөөллөөс эвдэгдсэн хөрс, газрыг булах, тэгшлэх, ургамалжуулах замаар цаашид нийтийн хэрэгцээний зориулалтаар ашиглахуйц байдалд оруулж, нөхөн сэргээх арга хэмжээг авах;

2.6.2. Мо Эн Ко компани нь усны нөөцийг зохистой ашиглах үүднээс Төслийн үйл ажиллагаанд үйлдвэрлэлийн болон уурхайн тоосжилт дарах зориулалтаар газрын гүний усыг аль болох хэрэглэхгүй байх, гадаргын усыг хуримтлуулах замаар хиймэл нуур, цөөрмийг бий болгон үйлдвэрлэлийн хэрэгцээнд ашиглах боломжийг судалж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2.6.3. МоЭнКо компани нь байгаль орчныг нөхөн сэргээх төлөвлөгөөний хүрээнд хөрс хуулалт хийсэн талбайтай тэнцэхүйц хэмжээний газарт дүйцүүлэн ойжуулалт хийх ба уг газрын байршлыг Ховд аймагтай тохиролцож байх;

## **2.7. Төслийн үйл ажиллагааны талаархи мэдээллийг иргэд, олон нийтэд ил тод байх нөхцлийг бүрдүүлэх.**

2.7.1. Төслийн талаарх мэдээллийг орон нутгийн төр захиргааны байгууллага, нутгийн иргэдэд цаг тухайд нь өгч хамтарч ажиллах, олборлох үйлдвэрийн

санаачилгын ил тод байдлын тайланг хагас, бүтэн жилээр гаргаж олон нийтэд мэдээлэх;

2.7.2. Төслийн үйл ажиллагааг хуулийн хүрээнд дэмжиж, ард иргэдэд үнэн бодит мэдээлэл өгч, улирал тутам Төслийн талаарх мэдээллийг Засаг даргын Зөвлөл, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар сонсож, шаардлагатай арга хэмжээг авах;

**2.8. Хөшөөт төслийг хэрэгжүүлэхэд орон нутгийн холбогдох төр, захиргаа, өмчийн бүх хэвшлийн байгууллагуудын ажлын уялдаа, хамтын ажиллагааг хангах бодлогын хүрээнд удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах.**

**А. Ховд аймгийн хувьд:**

2.8.1. Орон нутгийн иргэд, олон нийтийн байгууллагын зүгээс төслийн үйл ажиллагааг хууль бусаар тасалдуулах, хэвийн байдлыг алдагдуулах нөхцөл байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх, нэн даруй таслан зогсоох арга хэмжээ авах;

2.8.2. Төсөл хэрэгжиж буй Хөшөөтийн уурхайд нийгмийн хэв журмыг хангах зорилгоор уурхайн бүс нутагт байнга ажиллах цагдаагийн хэсэг буюу пост (2-оос доошгүй цагдаагийн ажилтан) байнга ажиллуулах талаар анхаарч холбогдох арга хэмжээ авах;

2.8.3. Төслийн хэрэгжилтийн явцад мэргэжлийн болон иргэний нийгмийн байгууллагуудын хяналтыг үе шаттайгаар хийлгэх ажлыг зохион байгуулах;

2.8.4. Төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой МоЭнКо компанийн зүгээс тавьсан санал, хүсэлтийг төрийн холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

**Б. Мо Эн Ко ХХКомпаний хувьд:**

2.8.5. Орон нутгийн иргэд болон төрийн захиргааны байгууллагын зүгээс хуулийн хүрээнд тавьж буй аливаа хүсэлт шаардлагыг хүлээн авч шийдвэрлэж байх;

2.8.6. Уг гэрээнээс гадуурх орон нутгийн улс төрийн нам, бүлгүүдээс ирсэн хандив, тусламжийн хүсэлтийг хүлээн авахгүй ба ийм хүсэлтийг Ховд аймагт тухай бүр мэдээлэх.

---oOo---